



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 3-р сарын 18-ны өдөр
Зээлийн дугаар, нэр L3287, L3288-MON (SF):
“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт”
Гэрээний дугаар, нэр W0004: Бэлчээрт ус цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил
Тендер хүлээн авах эцсийн огноо ба цаг: 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 10.00 цаг

1. Монгол улс Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх)-наас “**Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт**” төслийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурдсан гэрээний хүрээнд хийгдэх төлбөрт ашиглана. Энэхүү гэрээг АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны харьяат тендер оролцогчдод нээлттэй байна.

2. **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь** эрх бүхий тендер оролцогчдоос Бэлчээрт ус цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил (цаашид “ажил” гэх)-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Энэхүү худалдан авах ажиллагаа нь дараах багцаас бүрдэнэ. Үүнд:

1-р багц: Баянхонгор аймгийн бэлчээрт ус цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил;

2-р багц: Дорноговь аймгийн бэлчээрт ус цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил;

3-р багц: Дорнод аймгийн бэлчээрт ус цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил;

4-р багц: Өмнөговь аймгийн бэлчээрт ус цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил.

3. Тендер оролцогч нь тендерийн баримт бичигт тодорхойлсны дагуу нэг эсхүл хэд хэдэн багцын шалгаруулалтад оролцох боломжтой. Нэгээс дээш тооны багцын гэрээ байгуулах эрх олгогдсон тохиолдолд үнийн хөнгөлөлт эдлэх саналтай тендер оролцогчдын хувьд энэхүү үнийн хөнгөлөлтүүд нь Тендер ирүүлэх маягтад тусгагдсан байгаа нөхцөлд энэхүү саналаа гаргаж болно.

4. Энэхүү тендер шалгаруулалтыг АХБ-ны дүрэм, журмаар явуулна.

5. Зөвхөн доор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендер оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно:

- БОАЖЯ-наас олгосон усны геофизикийн хайгуул, судалгааны ажил явуулах тусгай зөвшөөрөл;
- Ижил төстэй 1-ээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх, ингэхдээ тендер оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь түүний санал болгосон үнийн дүнгийн 20 хувиас багагүй байна;

- Тухайн гэрээнд шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө нь тухайн тендерт оролцогчийн санал болгосон үнийн дүнгийн 50 хуваас доошгүй хэмжээтэй байна;
- Тендерт оролцогч нь багц тус бүрт гэрээг гүйцэтгэх чадавх, туршлага бүхий удирдах болон техникийн голлох мэргэжилтэнтэй байх;
- Багц тус бүрт геофизикийн хайгуулын ажил явуулахад шаардлагатай хангалттай машин механизм, тоног төхөөрөмжтэй байх.

6. Эрх бүхий тендерт оролцогч нь **50,000.00 төгрөгтэй** тэнцэх эргэн үл төлөгдөх хураамжийг төлснөөр тендерийн баримт бичгийг худалдан авч болно. Төлбөр хийх арга нь **бэлэн мөнгө болон шилжүүлэг** байна.

Банкны мэдээлэл:

Банк:	Төрийн сан
Дансны нэр:	ХААХХТөслийн н.с /МТХ/
Дансны дугаар:	100900011606.

7. Тендерт оролцогч нь өөрийн санал болгож буй тендерийн үнийн дүнгийн 2%-тай тэнцэх үнийн дүнгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

8. Тендерийг дор дурдсан хаягаар, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендерийг **2020 оны 4-р сарын 1-ний өдрийн Улаанбаатарын цагаар 10.00 цагт**, эсхүл түүнээс өмнө урилгын төгсгөлд заасан хаягаар ирүүлнэ.

9. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана. Тендерийг **2020 оны 4-р сарын 1-ний өдрийн 10.10-г** нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.

10. Тендер бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор тендерт оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариуцахгүй.

Тендерийн баримт бичигтэй танилцах болон худалдан авах хаяг:

*“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төсөл
СБД, Бага тойруу 14200, Сүхбаатарын талбай 8/1,
Сити Тауэр, 9 давхар, 903А тоот, Улаанбаатар, Монгол улс
Утас: +976 11 322652 (ext 10)
Цахим шуудан: info@ardp.mn*

Тендер нээх газрын хаяг:

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЗГ-ын 9а байр, Энх тайваны өргөн чөлөө 1ба, 1-р давхар, Хурлын танхим
Улаанбаатар хот, Монгол Улс*